



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 4/59

Дадал сум

Зардал гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 03 дугаар хуралдааны 04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын 3.3.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор хамтарсан багийн ажлыг эрчимжүүлэх, хүүхэд хамгаалал, нөлөөллийн үйл ажиллагааны хүрээнд “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сургалтын хэрэглэгдэхүүний зардал гаргасугай.

2.Зардлын 247,000 (Хоёр зуун дөчин долоон мянга) төгрөгийг Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас гарган зарцуулахыг нягтлан бодогч (Д.Энхзул)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Д.Агаармандал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.МӨНХХУЯГ

010000210